

**ХҮНС ҮЙЛДВЭРЛЭЛ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
"ХӨВСГӨЛ ХҮНС"ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2016 онд “Хөвсгөл Хүнс”ХК нь Талх гурилан боов, жимс жимсгэний өтгөрүүлсэн шүүс вариань , ургамлын цай, сүүн ааруул, нөөшилсөн бүтээгдэхүүн гэсэн үндсэн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хөдөлмөрчдийн хэрэгцээнд нийлүүлсэн байна. Үүнд:

- Талх нарийн боов-65097.2 кг
- Варень – 2883 кг
- Чихэр – 1379 кг
- Хэрчсэн гурил -356 кг
- Жимсний шүүс-5278 л
- Загас -1623 кг
- Үзэмний шүүс, цай – 9729,8 литрийг үйлдвэрлэсэн байна.

“Хөвсгөл Хүнс”ХК нь 42 ажилчин албан хаагчтай 2016 онд ажилчдын тоогоо бууруулаагүй хадгалж, чацарганы тариан талбайд шинээр 4 хүний ажлын байр бий болгосон байна.

2016 онд “Хөвсгөл Хүнс”ХК нь Талх нарийн боовны сав баглаа боодлыг шинэчлэн сайжруулж бүтээгдэхүүний шинэ савлагаа шинэ өнгө төрхийг бий болгож зах зээлд нэвтрүүлсэн.

Аймгийн стандартчилал хэмжил зүйн газраас Жимсний бүх төрлийн шүүс вариань, чанамал гурилан бүтээгдэхүүн хэвийн боов, боорцог, танзуур мааюур, маахуур, Талх талхан бүтээгдэхүүнээс УБталх, Зохицуулах үйлчилгээтэй талх, Жигнэмэл гурилан бүтээгдэхүүнээс 15 нэр төрлийн бүтээгдэхүүн Тохирлын гэрчилгээ авсан байна. Мөн манай компанийн үйлдвэрлэдэг бүх төрлийн бүтээгдэхүүн GS-1 систем, зураасан код хэрэгжүүлсэн байна.

Байгаль орчин ногоон бизнесийг дэмжих чиглэлээр манай компани 2015 онд Мөрөн сумын нефт баазын баруун хойно 9 га газар 10000 ширхэг чацарганы модыг суулгасан байна. Модыг хөдөө аж ахуйн газраас 4000 ширхэгийг Увс аймгаас 6000 ширхэг чацарганы мод авч суулгасан билээ.

2016 онд нэмж шинээр 3000 модыг нөхөн сэргээлтэнд суулгасан байна. 2020 он гэхэд манай компани өөрийн чацарганы талбайгаас жилд 10 тонн чацаргана хураан авах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Экспортыг нэмэгдүүлэх импортыг орлох чиглэлээр манай компанийн Нэрсний өтгөрүүлсэн шүүс УБ хотод ҮХАА-н яамнаас зохион байгуулсан “Үндэсний брэнд-2015” үзэсгэлэн худалдаанаас “Импортыг орлох бүтээгдэхүүн” шагналыг авсан. 2016 онд “Хөвсгөл брэнд-

2016”, “Намрын ногон өдөр” үзэсгэлэн худалдаанаас Аньсны өтгөрүүлсэн шүүс “Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн”-ээр шалгарсан. Мөн манай компанийн нөөшилсөн бүтээгдэхүүний цехийн загас /консерв/ адуу үхрийн нөөшилсөн мах зэрэг бүтээгдэхүүнүүд импортыг орлох чиглэлээр хийж буй ажил юм.